

COVID-19 ХОЛБООТОЙ ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДААС ГАРГАСАН БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖҮҮД, ТҮҮНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

А.Энхбат*, Ж. Шинэгэрэл**

Хураангуй: Энэхүү судалгааны ажлаар COVID-19 тахлын үеийн эдийн засгийг эрсдэл багатай даван туулахад зориулан Дэлхийн банк, Олон улсын валютын сан, Дэлхийн эдийн засгийн форум, Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага гэсэн олон улсын санхүүгийн байгууллагуудаас гаргасан бодлогын баримт бичгийг судлан, тэдгээрт тусгасан бодлогын зөвлөмжүүдийг Монгол Улс цар тахлын үед эдийн засгийн эрсдэлийн эсрэг хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүдтэй харьцуулан харуулав.

Түлхүүр үгс: Нөхөн сэргэлтийн үе, Нөхөн сэргээх арга хэмжээ, Эдийн засгийг дэмжих арга хэмжээ, Эрсдэлийг бууруулах арга хэмжээ

COMPARED POLICY ANALYSIS ON POLICY RECOMMENDATIONS FROM INTERNATIONAL FINANCIAL INSTITUTIONS FOR ECONOMIC DOWNTURN CAUSED BY COVID-19 PENDING

Summary: This study examines policy recommendations issued by four major international financial institutions, the World Bank, the International Monetary Fund, the World Economic Forum, and the Organization for Economic Co-operation and Development, to address the economic downturn driven by COVID-19 epidemic. The recommendations are analyzed and compared with the policy measures implemented in Mongolia against the economic risks of the pandemic.

Key words: Recovery stage, Recovery measures, Economic support measures, Risk mitigation measures

¹ МУИС-ийн Бизнесийн сургууль (E-mail): enkhbatamarjargal@gmail.com

² МУИС-ийн Бизнесийн сургууль (E-mail): shgerel@gmail.com

Оршил

Олон улсын валютын сангаас гаргадаг Дэлхийн эдийн засгийн төлөв тайлангийн 2019 оны дугаарт дэлхийн эдийн засгийн өсөлт 2019 онд 3% болно гэж таамагласан нь 2008-2009 онд өрнөсөн дэлхийн эдийн засгийн хямралаас хойш үүсэх хамгийн бага төвшин юм. Харин 2020 онд дэлхийн эдийн засгийн өсөлт 3,4% хүрч дахин өсөх хандлагатай байгааг тус тайланд дурдсан [20]. Азийн хөгжлийн төлөв тайлангийн 2019 оны дугаарт Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2019 онд 6.7 хувь хүрэх ба 2020 онд бага зэрэг буурч 6.3 хувь болно гэж таамагласан байна. Харин дотоодын эрэлт өсөх, үйлчилгээ болон боловсруулах үйлдвэрлэл тогтворжих, хөдөө аж ахуйн салбар сэргэх зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр тогтвортой байна гэж үзэв [8]. Харин Covid 19 цар тахал гарч дэлхий даяар тархсаны дараа гарсан дээрх тайлангийн 2020 оны дугаарт дурдсанаар Монгол Улсын ДНБ-ны өсөлт 2020 онд огцом буурч 2,1 хувьд хүрнэ гэсэн таамаглал гаргажээ. Энэ нь 2019 оны 2 дугаар хагасаас ажиглагдаж эхэлсэн бөгөөд 4 дүгээр хагаст 2,2 хувь хүртэл огцом буурсан. COVID19 цар тахал газар авч БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарсантай холбоотойгоор Монгол Улсын түүхий эдийн эрэлт, бараа материалын үнэ буурч, нүүрс, зэс, төмрийн хүдэр, цайр, түүхий тос зэрэг түүхий эдийн экспортын хэмжээ буурах төлөв харагдаж байна. Цар тахлын улмаас БНХАУ-руу гарах нүүрсний экспорт зогсож, зорчигч тээвэрлэлт их хэмжээгээр буурснаар ашигт малтмалын нэмүү өртөг багасна. Харин 2021 оноос худалдааны хурцадмал байдал болон COVID19-н тархалт намжиж БНХАУ-ын нөхцөл байдал хэвийн болсноор манай улсын коксжих нүүрсний экспорт эргэн сэргэж Оюу Толгойн ашигт малтмалын ордын хүдрийн чанар, гарц сайжирч Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2021 онд 4,6 хувь болж эргэн сэргэнэ гэж тус тайлангийн 4-р сарын дугаарт дурджээ [5]. Харин тус тайлангийн 9-р сарын дугаарт Монгол улсын ДНБ-ны өсөлт 2020 оны 6-р сард (-1,9) хувь 9-р сард (-2,6) хувьд хүрснийг онцолжээ [6].

Цар тахал гарахаас өмнөх судалгаануудаас харахад эдийн засгийн өсөлт харьцангуй тогтвортой байна гэсэн хандлага харагдаж байсан бол түүнээс хойш гарсан судалгааны үр дүнгээс харахад 2020 онд Монгол Улс болон дэлхийн ихэнх улс орны эдийн засгийн өсөлт огцом буурах дүр зураг ажиглагдаж байна.

Эдийн засаг эргэж хурдацтай сэргэх үйл явц нь хямралын үед авч хэрэгжүүлсэн бодлогоос ихээхэн хамаарна. Тиймээс олон улсын санхүүгийн байгууллагууд хямралын үеийг эрсдэл багатай давахад улс орнуудад зориулан бодлогын зөвлөмжүүдийг гаргасаар байгаа. Энэхүү судалгааны ажлаар тэдгээр зөвлөмжүүдийг судлан дүн шинжилгээ хийлээ.

1) Олон улсын валютын сангаас гаргасан бодлогын зөвлөмжүүд

ОУВС-ын удирдах зөвлөлөөс COVID19-с үүдэлтэй эрсдэлд хамгийн их өртсөн салбар, нийгмийн эмзэг бүлгийг дэмжих зорилгоор 99 сая орчим ам.доллартой дүйцэхүйц санхүүжилтийг түргэн авах хэрэгслийн хүрээнд яаралтай санхүүжүүлэхийг хүссэн Монгол Улсын хүсэлтийг дэмжиж баталсан [17].

ОУВС-ын судлаачдын тодорхойлсноор Covid-19 нь ихэнх талаараа дайны үетэй адил нөхцөл байдал үүсээд байгаа учраас төрийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг маш чухал ба бодлого боловсруулахдаа хоёр үе шатыг салгаж авч үзэх хэрэгтэйг онцолжээ [14]. Үүнд:

- ❖ 1-р үе буюу дайны үе: Цар тахал эрчимтэй үргэлжлэнэ. Хүмүүсийн амь насыг аврахын тулд эдийн засгийн ихэнх үйл ажиллагааг таслан зогсооно. Энэ үе хамгийн багадаа нэгээс хоёр улирал үргэлжилнэ.
- ❖ 2-р үе буюу дайны дараах сэргэлтийн үе: Эм, вакцин, дархлаажуулалт, хязгаарлалтын арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлснээр цар тахлыг хяналтандаа авч хорио цээр тавигдаж эдийн засаг сэргэж хэвийн байдалдаа орно [14].

Дайны үеийн бодлогын арга хэмжээ

Одоо өрнөж буй хямралаас үүссэн нөхцөл байдал нь эрэлтээс шалтгаалаагүй харин өвчний тархалтыг хязгаарлах зайлшгүй арга хэмжээний үр дүнд бий болсноороо бусад эдийн засгийн хямралаас ялгаатай. Тиймээс эдийн засагт хэрэгжүүлэх бодлого нь эрэлтийг өдөөхөөс илүү дараах гурван гол зорилтод чиглэх ёстой гэж үзжээ. Үүнд:

- ❖ **Гол салбаруудын үйл ажиллагааг баталгаажуулах:** COVID19-н шинжилгээ, эмчилгээний эх үүсвэрийг нэмэгдүүлэх шаардлагатай. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хоол хүнс үйлдвэрлэх, түгээх гэх мэт зайлшгүй шаардлагатай дэд бүтэц, хангамж хэрэгслийг тогтмол ажиллуулах шаардлагатай.
- ❖ **Хямралд өртсөн ард иргэдийг хангалттай нөөцөөр хангах:** Хориг арга хэмжээ хэрэгжүүлсний үр дүнд шууд болон шууд бусаар орлогын эх үүсвэрээ алдсан өрхүүдэд засгийн газрын дэмжлэг зайлшгүй шаардлагатай. Ажилчдад цалинтай чөлөө олгосноор ажлын байраа алдахгүйгээр гэртээ байх нөхцөл бүрдэхээс гадна хүмүүсийн хөдөлгөөнийг багасгаж халдвар тархах эрсдэлийг бууруулна. Мөн ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлж хугацааг сунгах

шаардлагатай. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон ажилгүй иргэдэд мөнгөн тэтгэмж олгох хэрэгтэй.

- ❖ **Эдийн засгийн хэт их хямралаас урьдчилан сэргийлэх:** Ажилчид ажил олгогчид, үйлдвэрлэгч хэрэглэгч, зээлдэгч зээлдүүлэгч нарын хоорондын харилцааг баталгаажуулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлснээр эрүүл мэндийн онц байдал намжсаны дараа бизнесүүд илүү эрчтэй үр ашигтайгаар үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх нөхцөл бүрдэнэ. Засгийн газраас хувийн хэвشلүүдэд цалингийн дэмжлэг өгөх гэх мэт тохирсон нөхцөлөөр онцгой дэмжлэг үзүүлэх хэрэгтэйг ОУВС онцолж байна [14].

ОУВС-ын тодорхойлсноор өрх гэр, бизнесийн байгууллагууд, санхүүгийн салбарыг дэмжих бодлого нь зээл олгох, санхүүгийн үүргийг хойшлуулах гэх мэт хөрвөх чадварын арга хэмжээ болон бодит нөөцийг шилжүүлэх гэх мэт төлбөрийн чадварын арга хэмжээнүүдээс бүрдэж байна. (хүснэгт 1-г харна уу)

Хэрэв томоохон корпорацуудад санхүүгийн дэмжлэг, хөнгөлөлттэй зээл олгох бол ажлын байрыг хадгалах нөгөө талаас гүйцэтгэх захирлын нөхөн олговор, ногдол ашиг, хувьцааны худалдан авалтыг хязгаарлах нөхцөлтэй олгох хэрэгтэй. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүмүүст өмнөх онуудын татвар төлсөн байдал дээр үндэслэн зээл, санхүүгийн дэмжлэг, бэлэн мөнгө олгох хэрэгтэй ба эдгээр дотоод бодлогын арга хэмжээнүүдийг олон улсын худалдаа, хамтын ажиллагааны дэмжлэг туслалцаатай хэрэгжүүлснээр цар тахалтай тэмцэх, нөхцөл байдал эргэж хэвийн болох хугацааг нэмэгдүүлэх боломжтой болно гэсэн бодлогын зөвлөмжийг ОУВС өгч байна [14].

Хүснэгт 1. Олон улсын валютын сангаас гаргасан covid 19 цар тахлын үед авч хэрэгжүүлэх эдийн засгийн бодлогын хувилбарууд

| | ХӨРВӨХ ЧАДВАР | ТӨЛБӨРИЙН ЧАДВАР |
|------------|--|---|
| | Орон сууц болон оюутны зээлийн төлбөрийг түр зогсоох | Бэлэн мөнгөний шилжүүлэг |
| ӨРХ | Татварын болон нийгмийн даатгалын шимтгэлийн хугацааг хойшлуулах | Ажилгүйдлийн даатгал |
| | | Сургуулиас хол байгаа оюутнуудад олгох ваучер |

| | | |
|---|--|--|
| БИЗНЕС | Зээлийн хугацааг сунгах | Нэмэлт хөрөнгө |
| | Татвар нийгмийн даатгалын шимтгэлийг хойшлуулах | Хөдөлмөр эрхлэлтийг хангахад дэмжлэг үзүүлэх |
| | Үнэт цаас болон бонд худалдан авах | ААН-н өмнөх оны татвар болон борлуулалтад үндэслэн дэмжлэг үзүүлэх |
| | Төв банкнаас зээлийн хөнгөлөлт үзүүлэх | |
| | Зээлийн баталгаа | |
| САНХҮҮГИЙН САЛБАР | Санхүүгийн салбарын хөрвөх чадварын баталгаа | Нэмэлт хөрөнгө |
| | Зах зээлийн хөрвөх чадварыг хадгалах арга хэмжээ | Засгийн газрын баталгаа |
| Тайлбар: Хөрвөх чадварын арга хэмжээнд зээл болон төлбөрийн чадварын арга хэмжээ орно. Төлбөрийн чадварт шилжүүлэг, төлбөрөөс чөлөөлөх, буцалтгүй тусламж, бараа, үйлчилгээ зэрэг орно. | | |

Эх сурвалж: International Monetary Fund: <https://blogs.imf.org/2020/04/01/economic-policies-for-the-covid-19-war/>

Нөхөн сэргэлтийн үе

ОУВС-н үзэж байгаагаар нөхөн сэргэлтийн үед их хэмжээний улсын өр болон эдийн засгийн шинэчилсэн бодлогыг хэрэгжүүлэх гэх мэт бэрхшээлүүд тулгарах боловч 1 дүгээр үед авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээг амжилттай хэрэгжүүлснээр эргэн хэвийн байдалд хурдан орох нөхцлийг бүрдэх боломжтой [14].

Нийлүүлэлтийн сүлжээнд их хэмжээний тасалдал үүсэхээс сэргийлж чадвал ОУВС-с тодорхойлсон дээрх хоёр үед инфляц үүсэхээс сэргийлж чадах ба вирусийн тархалтыг бууруулах арга хэмжээг амжилттай хэрэгжүүлсэн тохиолдолд улсын өрийн харьцаа хэвийн хэмжээнд байх боломжтой. Гэвч зээлийн хүү болон нийт эрэлтийн хэмжээ нөхөн сэргэлтийн үе шатанд бага төвшинд байх төлөвтэй байгааг ОУВС-аас сануулж байна. Ийм нөхцөлд хөгжингүй эдийн засагтай улс орнууд эдийн засгийг дэмжих багц арга хэмжээ хэрэгжүүлбэл үр дүнтэй ба ингэснээр нөхөн сэргэлтийн үед онц байдлын үед хэрэгжүүлж байсан арга хэмжээг хэрэгжүүлэхээ зогсооход түлхэц болно гэж зөвлөжээ [14].

ОУВС-ын судлаачид цар тахалтай холбоотой улс орнуудын туршлагыг судалж түүн дээр үндэслэн бодлогын зөвлөмжийн цуврал нийтлэлүүдийг

тогтмол гаргаж байна. Үүнд:

Тусгай сан байгуулах

Дэлхийн 40 гаруй улс орон COVID19-н эсрэг авах үйл ажиллагаанд зориулж улсын төсвөөс гадуур тусгай сан байгуулсан. ОУВС-н зарим мэргэжилтнүүд³ тэдгээр улс орнуудын туршлага, түүний давуу болон сул талыг судалж, хэрхэн үр дүнтэй ашиглах, ил тод хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх талаар тус санг хэрэгжүүлэхээр төлөвлөж буй улс орнуудад зориулан зөвлөмж боловсруулсан байна [12]. Үүнд:

- ❖ Сангийн зорилго, санхүүгийн эх үүсвэр, түүний удирдлага, хяналтын бүтэц, үйл ажиллагаа, үйл ажиллагааг зохицуулдаг бизнесийн үйл явц, тайлагналын стандарт, нягтлан бодох бүртгэл, аудитын шаардлагыг тодорхой болгоход чиглэсэн батлагдсан хууль тогтоомжтой байх хэрэгтэй.
- ❖ Давхардлаас зайлсхийх, хуваагдмал байдлыг хязгаарлах, үйл ажиллагааны уялдаа холбоог хангахын тулд сангийн үйл ажиллагааны чиглэл, орлогын эх үүсвэрийг холбогдох засгийн газрын яамд, хөгжлийн түншүүд, төрийн бус байгууллагуудтай зөвшилцөн тодорхойлсон байх ёстой.
- ❖ Сан нь хуулийн этгээд бол зохистой менежментийн бүтэцэд стратегийн шийдвэр гаргах үүрэг бүхий бие даасан менежментийн хороо эсвэл зөвлөл, сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах ерөнхий удирдлагатай байх хэрэгтэй. Санхүүгийн менежерүүд, нягтлан бодогчид, худалдан авах ажиллагааны мэргэжилтнүүд, дотоод аудиторуудаас бүрдсэн итгэмжлэгдсэн баг удирдлагад туслацгаа үзүүлэх боломжтой байх. Тухайн итгэмжлэгдсэн багт Сангийн яам, худалдан авах үйл ажиллагааны байгууллагын хүчтэй төлөөлүүдийг багтаах.
- ❖ Боломжтой бол COVID-19 сан цахим хэлбэрээр гүйлгээ хийх шаардлагатай. Цахим гүйлгээ нь хурд, үнэн зөв байдлыг бий болгож, гүйлгээний бүртгэл хөтөлтийг хялбарчилж, үйл ажиллагааны зардлыг бууруулна.
- ❖ Засгийн газрууд COVID-19 сангийн үйл ажиллагааг вэбсайт дээрээ байршуулж, тэдгээрийн хууль ёсны бүрэн эрх, зорилго, бодлого, орлогын эх үүсвэр, засаглал, менежментийн зохицуулалт, үйл ажиллагааны дүрэм, журмыг тайлбарлах ёстой. Сангийн орлого, зарлагыг сар, улирал тутам нийтээр тайлагнах ёстой.

³ Fazeer Rahim, Richard Allen, Нийлне Barroy, Laura Gores, and Joseph Kutzin

- ❖ Улс орнууд өөрсдийн АТГ-г тус санд аудит хийх үүрэг даалгавар өгч, аудитыг цаг тухайд нь (зургаан сарын дотор) хийж хэвлэн нийтлэх хэрэгтэй. Түүнчлэн завсрын аудит, зэрэгцээ хяналт зэрэг шинэлэг механизмуудыг судлан хэрэгжүүлэх боломжтой.

Тэтгэврийн системийг ашиглах нь тохиромжгүй

Цар тахалын нөлөөгөөр бий болсон эдийн засгийн уналт нь ажил эрхлэлтийн төвшинг бууруулахаас гадна ажил эрхлэгчдийн идэвхтэй байдалд нөлөөлж байна. Тодруулбал тэтгэвэрт гарах дөхсөн ажил эрхлэгчид нь коронавируст өртөх эрсдэл ихтэй бүлэгт хамаарах тул ажлаасаа бүр мөсөн гарч тэтгэвэрт эрт гарахыг эрмэлзэж болно. Эдгээр нь улсын тэтгэврийн зардлын тогтвортой байдал, хүрэлцээтэй байдалд нөлөөлж байгаа ба хямралаас үүдэлтэй төсвийн ерөнхий дарамтыг нэмэгдүүлж болзошгүйг ОУВС-ын зарим судлаачид онцолсон байна⁴. Тиймээс улс орнууд хямралаас үүдэлтэй сөрөг нөхцөл байдлыг арилгахын тулд тэтгэврийн системийг ашиглахаас татгалзах, тэтгэврийн зардлыг хянах зорилгоор хэрэгжүүлж буй бодлогын шинэчлэлүүдийг зогсоохгүй байх хэрэгтэй гэсэн зөвлөмж өгч байна [11].

Хямралын үед улсын төсвийг боловсруулах нь: 2021 оны төсвийн төслийг боловсруулах зөвлөмж

2020 оны төсвийн гүйцэтгэл төлөвлөгөөнөөсөө нэлээд зөрүүтэй байгаа тул хямралын үеэр төсөвлөх нь Сангийн яамдад ачаалал өгч байна [33].

Хүснэгт 2. 2021 оны төсвийг бэлтгэхэд анхаарах гол асуудлууд

| Үе шат | Анхаарах асуудал |
|-------------------------------------|--|
| Ерөнхий | <ul style="list-style-type: none"> Стратегийн удирдамж болон төвлөрсөн удирдлагын системийг сайжруулах, байгууллагууд болон үйл ажиллагаанд зай барих (social distancing) шаардлагыг оруулж өгөх |
| Стратеги боловсруулах үе шат | <ul style="list-style-type: none"> Эдийн засгийн хямрал болон Covid19-н эсрэг хэрэгжүүлэх арга хэмжээний нөлөөллийг бодолцож макро-эдийн засгийн тогтолцоог хянан сайжруулах, урьдчилсан тоон мэдээнд үндэслэн тогтмол шинэчлэх Дунд шатны шинэчилсэн төсвийн зорилгод тулгуурлан найдвартай стратеги боловсруулах |

⁴ Csaba Feher and Ignatius de Bidegain нар

| | |
|---|--|
| Төсвийн удирдамж, хэлэлцээрийн үе шат | <ul style="list-style-type: none"> ▪ Зарцуулалт болон хуваарилалтын хэрэгцээний талаар салбар яамдуудтай эрт холбогдож, тодорхой мэдээлэл өгөх ▪ Ердийнхөөс илүү ачаалалтай байхаар төлөвлөж төсвийн суурь хэмжээг тогтоох ▪ 2021 оны төсөв нь COVID-19-тэй холбоотой шинээр хэрэгжүүлж буй бодлогын зардал, эрүүл мэндийн хямралын нөлөөлөл зэрэг төсвийн суурь хэмжээний талаар эрчимтэй хамтран ажиллах шаардлагатай |
| Төсвийн удирдамж, хэлэлцээрийн үе шат | <ul style="list-style-type: none"> ▪ Илүү уян хатан төсвийн бодлого боловсруулах, төлөвлөх гүйцэтгэх удирдлагын хариу үйлдлийн хэрэгцээг хууль тогтоогч байгууллагын хяналт шалгалтын хэрэгцээтэй тэнцвэржүүлэх ▪ Төсвийн гүйцэтгэлийн явцад илүү нягт хяналт шаардлагатай байгааг харгалзан төсвөө боловсруулах |
| Төсвийн баримт бичиг, хууль тогтоомж батлах үе шат | <ul style="list-style-type: none"> ▪ Төсвийн баримт бичгийг ашиглан маш тодорхой дүр зургийг тодруулж, засгийн газрын төсөв, эдийн засаг, нийгмийн стратегид итгэх итгэлийг бэхжүүлэх |

Эх сурвалж: International Monetary Fund: [file:///C:/Users/User/Downloads/en-special-series-on-covid-19-budgeting-in-a-crisis-guidance-on-preparing-the-2021-budget%20\(1\).pdf](file:///C:/Users/User/Downloads/en-special-series-on-covid-19-budgeting-in-a-crisis-guidance-on-preparing-the-2021-budget%20(1).pdf)

2) Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагаас гаргасан бодлогын зөвлөмжүүд

ЭЗХАХБ-ын үзэж байгаагаар COVID19 цар тахал нь засгийн газрын үйл ажиллагаа болон эдийн засагт богино – урт – дунд хугацааны нөлөөлөл үзүүлж байгаа бөгөөд богино хугацаанд онц байдлыг намжаах, эрүүл мэндийн хямралыг шийдэх асуудал нэн тэргүүнд тавигдах бол дунд хугацаанд эдийн засаг, нийгмийн болон санхүүгийн хямралыг зохицуулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд анхаарах хэрэгтэй. Урт хугацаанд авах арга хэмжээ нь нийгэм эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэх ёстой [30]. (График 1-г харна уу). Цар тахлын нөлөөгөөр богино хугацаанд эрүүл мэнд болон нийгмийн зардлууд нэмэгдэж харин дунд хугацаанд орлого зарлагын хэмжээнд сөргөөр нөлөөлнө. Богино хугацаанд бизнес эрхлэгчид болон ажилчдад мөнгөн дэмжлэг хамгийн хэрэгтэй бол бусад төрлийн эдийн засгийн дэмжлэг нь дунд болон урт хугацаандаа илүү үр дүнтэй байх болно [30]. ЭЗХАХБ-ын үзэж байгаагаар COVID-19 тахал өвчний эдийн засгийн үр дагаврыг бууруулахын тулд ард иргэд ажил орлогоо хадгалахад чиглэсэн бодлогын яаралтай арга хэмжээ авах хэрэгтэй. Мөн ил тод, цаг хугацаатай, пропорционал, ялгаварлан

гадуурхалгүй байх үед дэмжлэг хамгийн ашигтай байдаг бөгөөд санхүүгийн системээр дамжуулан үзүүлэх дэмжлэг нь чухал үүрэгтэй боловч тодорхой хяналт тавих шаардлагатай байдаг гэдгийг онцолж байна. Түүнээс гадна бодлогын хэрэгжилтийн ил тод байдлыг хангах нь маш чухал. Бодлогын ил тод байдал нь засгийн газрын хариуцлагатай байдал, тэдний авсан арга хэмжээнүүдэд хяналт тавих боломжийг олгодог. Хэрэгжүүлсэн бодлого, зарцуулсан хөрөнгийн талаарх нарийвчилсан мэдээлэл нь засгийн газрын бодит өртгийг үнэлэхэд тусалж, үр дүнгийн байдлыг илтгэж өгдөг [28]. Богино хугацаанд бизнес эрхлэгчид болон ажилчдад мөнгөн дэмжлэг хамгийн хэрэгтэй бол дунд хугацаанд бусад төрлийн эдийн засгийн дэмжлэг илүү тохиромжтой. Түүнчлэн бизнес эрхлэгчид болон өрхүүдэд нийтийн үйлчилгээ үзүүлэх (жишээ нь, байр, нийтийн аж ахуй, ус, хог хаягдал, интернет холболт) -ийг зах зээлийн үнээс доогуур үнээр тооцох боломжтой гэдгийг ЭЗХАХБ дурдсан байна (OECD, 2020)⁵.

График 1. Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагаас гаргасан богино, урт, дунд хугацаанд бүс нутгийн төвшинд хэрэгжүүлэх бодлогын зөвлөмжүүд

| Богино хугацааны арга хэмжээ: они байна, нийтийн болон эрүүмэндийн хямралыг | Дунд хугацааны бодлого: эдийн засаг, нийгэм, улсын санхүүгийн хямралыг удирдах | Урт хугацааны асуудлууд: илүү тогтвортой нийгэм бий болгох боломж бүрдүүлэх |
|---|---|---|
| <ul style="list-style-type: none"> - Эрүүд мэндийн хямралтай тэмцэх арга хэмжээ авах: - Эрүүд мэндийн үйлчилгээг даивчлах - Нийгмийн үйлчилгээг даивчлах гэх мэтэг бүтэйн хүмүүст яаралтай тусламж үзүүлэх - Эрүүд мэндийн хямралтай холбоотой харилцаа, мэдээллийн систем/үйлчилгээг сайжруулах • Хямралын үеийн босоо болон хэвтээ олон түвшний зохицуулалтын механизмдыг идэвхжүүлэх • Бүс нутгийн төрийн үйлчилгээг хурц арга хэмжээүүдтэй уялдуулах: - Нийтийн үйлчилгээ, олон нийтийн газрыг түр хаах, сургууль, олон нийтийн барилга, зах тээв мэт. - олон нийтийн чухал үйлчилгээ, ж.нь, ус, хог хаягдал, нийтийн эзэмшлийн талбайг тэмдэрх, нийтийн тээвэр, захиргааны үйлчилгээ, нийтийн хэв журам, аюулгүй байдал гэх мэт. • Төсө-үйлчилгээг хөгжүүлэх • Бүс нутгийн төрийн санхүүг ашиглах. - эрүүд мэнд, нийгмийн шаардлагатай зардалыг гаргах - давс хаах болон 2020 оны төсөв батлах хугацааг хойшлуулах • Бүс нутгийн байгууллагуудыг ашиглах: - Уж төрийн байгууллагууд - Захирагын менежмент ажь хүний нөөц гэх | <ul style="list-style-type: none"> Нутаг дэвсгэрийн төвшинд эдийн засаг, нийгмийн хямралыг даван туулах: • Бүс нутгийн засаглалын эдийн засгийн сүргээх бодлого (ЖДҮ-г дэмжих, улсын хөрөнгө оруулалтыг дэмжих төлөвлөгөө) • Бүс нутгийн засаглалын нийгмийн бодлого - Хамгийн их өрсөн нутаг дэвсгэрийг нөхөн сэргээх бодлого Бүс нутгийн түвшинд санхүүгийн хямралыг даван туулах: • Бүс нутгийн засаглалын оролтын бууралтыг нөмрөх, зардлыг нэхэн өсөлтийг даван туулахад туслах бүс нутгийн санхүүжилтийг дэмжих бодлого/боловруулах (нийгмийн тэтгэмж, эмзэг бүтцийн иргэдэд үзүүлэх тусламж, эдийн засгийн сэргэлт) • Бүс нутгийн өрийн хямралыг удирдах • Төсвийн гарах стратегийг урьдчилан харах • Төрийн үйлчилгээг хурцх бүс нутгийн захиргааны болон үйл ажиллагааны зохион байгуулалтыг хяналт тавих • Хямралтай тэмцэх олон түвшний зохицуулалтын механизмдыг хянах - Хямралын менежментийн босоо болон хэвтээ зохицуулалтын механизмдыг үнэлж, хямралтай тэмцэх үйл явцыг сайжруулах | <ul style="list-style-type: none"> • Олон түвшний засаглалын туршвагуудыг судлах, сайжруулах: - Засгийн газрын төвшин бүрд гүйцэтгэх асуудлыг илүү тодорхой хуваарилах - Илүү баг бох, хурдан дасан зохицох механизм - Оши байдлын үед үр дүнтэй арга хэмжээ авах олон төвшиний харилцаа холбоо • Бүх нутаг дэвсгэр, ард иргэдийн эрүүд мэндийг хамарсан хяналт, хүртээмжтэй, чанартай үндсэн үйлчилгээний хангах • Бүс нутгийн хэмжээнд засаглалыг сайжруулах дараалал хэрэгсэл, үйлчилгээг хөгжүүлэх • Бүс нутгийн/орон нутгийн хөгжлийн шинэ загварыг бий болгох, хот, хоолооны бүсийг тэмцэрхүүлэх • ТББ, ард иргэд, бизнесүүдийн төрийн захиргаанд илүү оролцох механизмийг сайжруулах • Ногоон эдийн засаг руу шилжих үйл явцыг дэмжих |

Эх сурвалж: OECD: https://read.oecd-ilibrary.org/view/?ref=128_128287-5agkkojaaa&title=The-territorial-impact-of-covid-19-managing-the-crisis-across-levels-of-government

⁵ Ibid at 19

3) Дэлхийн банкнаас гаргасан бодлогын зөвлөмж

Цар тахалтай тэмцэх макро эдийн засгийн бодлогууд нь **тусламжийн арга хэмжээ, нөхөн сэргээх бодлого, олон улсын зохицуулалт** гэсэн гурван чиглэлээр хийгдэж болно.

Тусламжийн арга хэмжээ: ДБ-ны санал болгож байгаагаар цар тахалтай тэмцэхийн тулд дараах тусламжийн арга хэмжээг авах хэрэгтэй [25].

- a) Хүнд өвдсөн өвчтөнүүдийг эмчлэх эрүүл мэндийн тогтолцооны чадавхыг сайжруулах зорилгоор эрүүл мэндийн үйл ажиллагаатай холбоотой зардлыг нэмэгдүүлэх, мөн урьдчилан сэргийлэх, эмчилгээ үйлчилгээ үзүүлэх зорилгоор үнэ төлбөргүй, тусламжийн эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх
- b) Бэлэн мөнгө тараах гэх мэт эмзэг бүлгийн ард иргэдэд шууд орлогын дэмжлэг үзүүлэх, ялангуяа хорио цээрийн дэглэмтэй үед айл өрхүүдэд тулгарч болох санхүүгийн бэрхшээлийг бууруулахын тулд энэ арга хэмжээг яаралтай авах хэрэгтэй
- c) Хямралын нөлөөлөлд өртсөн салбар, байгууллагуудыг дэмжих зорилгоор татварыг түр хугацаанд хөнгөлөх, зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах арга хэмжээ авах

Засгийн газрын зардал нь эрүүл мэндийн үйлчилгээний хүчин чадлыг нэмэгдүүлэхэд чиглэх хэрэгтэй. Бараг бүх хөгжингүй эдийн засгууд болон ихэнх хөгжиж буй эдийн засгууд эрүүл мэндийн салбарын зардлын шинэ арга хэмжээг авч эхэлсэн.

Засгийн газрын зардал нь хориг арга хэмжээ болон бууруулах арга хэмжээний улмаас үүссэн эдийн засгийн зарим алдагдлыг засахад чиглэх ёстой. Үйл ажиллагаа нь зогссон бизнесүүд, ажлаас чөлөөлөгдсөн цалингүй болсон ажилчдад дэмжлэг үзүүлснээр эдийн засагт хямрал учруулахгүйгээр social distancing арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг бий болгохоос гадна өөрийгөө гэртээ тусгаарлах шаардлагатай хүмүүст гадагш гарахгүй байхад нь түлхэц болох юм.

Хөгжиж буй эдийн засагтай ихэнх улс орнуудад бэлэн мөнгө тараах нь эдийн засгийн хямралаас сэргийлэх илүү үр дүнтэй арга бөгөөд хэрэгжүүлэхэд хамгийн хялбар арга зам байх магадлалтай. Нэг талаас энэ нь төрийн албан хаагчид гэх мэт орлого нь хэвийн үргэлжилж байгаа болон өндөр орлоготой бэлэн мөнгөний тэтгэмж авах шаардлагагүй ард иргэдэд очиж хэрэгцээгүй зардал гаргах эрсдэлтэй учраас зорилтот бүлгүүдийг сонгож хэрэгжүүлэх хэрэгтэй гэж тус судалгаагаар зөвлөсөн байна.

Засгийн газрууд болон төв банкуудаас бизнесийн байгууллагуудад зээлийн баталгаа, шууд зээл олгох, татварын хөнгөлөлт үзүүлэх, бэлэн мөнгө олгох арга хэмжээнүүдийг авч эхэлсэн ба зарим хөгжингүй эдийн засагтай улс орнууд томоохон хэмжээний хөтөлбөрүүдийг зарлаад байгаа. Жишээлбэл: Англи улсын төв банк мөнгөний урсгалын тасалдалтай тулгарсан ААН-үүдийн арилжааны бичгийг засгийн газрын нэрийн өмнөөс худалдан авч тэдгээр байгууллагуудад шууд зээл олгож эхэлсэн. [9] Төв банкууд бизнесийн байгууллагуудад олгох зээлд тасалдал үүсгэхгүй байж хангалттай хөрвөх чадвар бий болгох үүднээс зээлийн хүүгээ зээлийн хүүг бууруулж банкуудын зээл олгох боломжийг өргөжүүлсэн [19].

Нөхөн сэргээх арга хэмжээ: Мөнгөний бодлого сул хэрэгжиж байгаа манай улс шиг хөгжиж буй эдийн засагтай улс орнуудад Английн төв банкны хэрэгжүүлсэн туршлагатай адил арга хэмжээ буюу төв банкнаас ААН-үүдэд шууд зээл олгох аргыг ашиглаж болно гэж ДБ зөвлөжээ [25]. Сул дорой институцийн орчинтой улс оронд шууд зээл олгох арга хэмжээг хэрэгжүүлэхэд ихээхэн бэрхшээлтэй тулгардаг учраас хөгжиж буй эдийн засгийн бодлого хэрэгжүүлэгчид мөнгөний бодлого хэрэгжүүлснээр үр дүн гарахгүй бол эрэлтийг өдөөх төсвийн бодлогод шилжих хэрэгтэйг дурдсан байна. ДНБ-д татварын орлогын эзлэх хувь доогуур буюу албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчид ажил эрхлэгчдийн ихэнх хувийг эзэлдэг улс оронд татварын хөнгөлөлтийн арга хэрэгсэл тохиромжгүй.

Олон улсын зохицуулалт: Хөгжиж буй эдийн засагтай улс орнууд нөхцөл байдал хурцдаж орлогын дэмжлэг, эрүүл мэндийн үйл ажиллагаанд санхүүжилт зайлшгүй шаардагдах үед орлогын хэмжээ нь багассан, санхүүгийн зах зээл ширгэсэн байх магадлалтай тул олон улсын санхүүгийн байгууллагуудаас санхүүжилт авах хэрэгтэй.

ДБ хөгжиж буй эдийн засагтай улс орнуудад макро экономикийн мөнгөний бодлого болон төсвийн бодлого хэрэгжүүлэх арга замыг санал болгож байгаа. Гэвч зарим улс оронд төсвийн хүрэлцээ хангалтгүй, бэлэн мөнгө тараах нь хүртээмж муутай байгаагаас болж эрэлт дээр суурилсан макро эдийн засгийн бодлогын арга хэмжээ авах нь үр дүн багатай байх магадлалтай. Энэ тохиолдолд төрийн болон эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа тасалдуулалгүй үргэлжлүүлж, эмзэг бүлгийн иргэдэд дэмжлэг үзүүлэх нь илүү үр дүнтэйг онцолсон. Мөн олон улсын санхүүгийн байгууллагуудын хамтын ажиллагаа санхүүжилтийн тусламжтай цар тахлын улмаас бий болох эрсдэлийг багасгах боломжтой гэдгийг хөгжиж буй улс орнуудад зөвлөсөн байна .

Мөн улс орнууд хямралын үед 1) иргэдийн амь насыг аврах 2) ядуу буурай

эмзэг бүлгийн иргэдийг дэмжих 3) тогтвортой бизнесийн үйл ажиллагаа, ажлын байрны өсөлтийг дэмжих 4) нөхөн сэргээх бодлого, институт, хөрөнгө оруулалтыг бэхжүүлэх гэсэн дөрвөн гол бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгтэй гэж зөвлөсөн бөгөөд эдгээр арга хэмжээ тус бүр нь тусламж, бүтцийн өөрчлөлт, тэсвэртэй байдлыг сэргээх гэсэн гурван үе шаттай бодлогын арга хэмжээнүүдийг авахыг зөвлөжээ [36].

4) Дэлхийн эдийн засгийн форумаас гаргасан бодлогийн зөвлөмж

Эрүүл мэндийн салбар цар тахлын эсрэг авах арга хэмжээнүүдийн анхаарлын гол төвд байх ёстой. Үүнээс гадна эдийн засгийн нөхөн сэргэлтийг даван туулахад бодлого боловсруулагчдад зориулж 4 төрлийн чиглэлд анхаарах ёстойг тодорхойлсон байна. Үүнд:

- ❖ **Компаниудад хурдан хугацаанд санхүүжилт олгох үр дүнтэй сувгийг тодорхойлох:** Жижиг дунд үйлдвэрүүдэд дэмжлэг үзүүлэх багц арга хэмжээнүүдийг улс орнууд хэрэгжүүлж эхэлсэн. Гэвч хангалттай хурдан хугацаанд буюу компани төлбөрийн чадваргүй болж, ажилчид хүнд байдалд орж системийн шинэ эрсдэл үүсэхээс өмнө санхүүжилт олгох суваг байгаа эсэх асуудал чухал. ЖДҮ эрхлэгчид хэдхэн долоо хоног, эсвэл хэдхэн хоногийн бэлэн мөнгөний нөөцтэй байхад засгийн газраас үзүүлэх дэмжлэгийг хэрэгжүүлэх процесс цаг хугацаа их шаардах тохиолдол их гардаг. ЖДҮ-т үзүүлэх бодлогын хэрэгжилтийг хурдасгахын тулд БНХАУ 2003 онд SARS халдварт өвчин гарахад дижитал эдийн засаг ашиглан ЖДҮ-үүдэд том мэдээллийн системийн өгөгдөл дээр суурилсан зээлийн үнэлгээний систем, зээлдэгчийг бодит цаг хугацаанд нь хянах санхүүгийн технологийн платформыг ашиглан онлайнаар зээл олгож яаралтай дэмжлэг хэрэгтэй зорилтот бүлгүүдэд хурдан хугацаанд хүрч үйлчилж байсан туршлагыг улс орнууд ашиглахыг ДЭЗФ-с зөвлөж байна.
- ❖ **Эмзэг бүлгийн ажилчид болон өрхүүдийг нарийвчлалтайгаар дэмжих:** Ажлын байран дээрээ заавал биеэрээ байх шаардлагатай, гэрээсээ ажиллах боломжгүй эрүүл мэнд, хоол хүнс, тээвэр ложистик гэх мэт өдөр тутмын үйлчилгээг хангадаг бага цалинтай зарим ажилчид хямралын үеийн эдийн засгийн уналтын нөлөөнд илүү их өртөж, бие махбодийн хувьд ачаалалтай сэтгэлзүйн дарамтанд ажиллаж байгаа. Англи, Герман, Швед, Норвеги гэх мэт европын орнуудад ажил олгогч, ажилтан хоорондын холбоог тасалдуулахгүйн тулд багасгасан цагийн хуваариар ажиллуулах бодлого баримталж байгаа [10]. Мөн

засгийн газраас дэмжлэг авсан ААН-үүдэд тодорхой хугацааны турш цомхтгол хийхгүй байх нөхцөлтэйгээр дэмжлэг үзүүлэх бодлого баримталж байна. ААН-үүдэд чиглэсэн арга хэмжээ үр дүн багатай байгаа тохиолдолд нийгмийн аюулгүй байдалд чиглэсэн бодлогыг давхар хэрэгжүүлэх хэрэгтэй. Ипотекийн зээлтэй өрх гэрүүдэд санхүүгийн нэмэлт орон зай үүсгэх зорилготой зээлийн хугацааг хойшлуулах гэх мэт бодлого хэрэгжүүлэх шаардлагатай.

- ❖ **Хямралд өртсөн бага болон дунд орлоготой улс орнуудад үүсэд байгаа зээлийн асуудлыг шийдвэрлэх:** Цар тахлын нөлөө хэд хэдэн нийлмэл хүчин зүйлсийн нөлөөгөөр бага болон дунд орлоготой оронд хүндээр нөлөөлж байна. Ялангуяа байгалийн нөөц үйлдвэрлэдэг экспортлогч улс орнууд газрын тос болон бусад түүхий эдийн үнийн уналтын нөлөөнд өртөж байна. ДЭЗФ-н үзэж байгаагаар доллараар зээл авдаг улс орнууд засгийн газрын оролцоонд шаардлагатай хөрөнгийг босгоход маш их бэрхшээлтэй тулгарна. ОУВС, Дэлхийн банк зээл өгөхөд бэлэн байгаагаа илэрхийлсэн ч тэдний эх үүсвэрийг өрийн моратория, дэвшилтэт эдийн засагтай орнуудын нэмэлт дэмжлэгээр нөхөх шаардлагатай [23]. Манай улсын экспортын 90 гаруй хувийг уул уурхайн салбар дангаар бүрдүүлдэг тул цар тахлын улмаас бий болж буй эдийн засгийн нөлөөнд хүчтэй өртөх улс орны тоонд зайлшгүй багтана.
- ❖ **Бодлогын тэргүүлэх чиглэлийг ДНБ-ны өсөлтөөс давуулж тэлэх замаар хориг арга хэмжээнүүдийг тэнцвэржүүлэх:** Цаг уурын өөрчлөлт, ногоон хөгжлийн асуудалд дэлхий нийт анхаарч улс орнуудын бодлогын хэмжээнд яригдаж байсан энэ үед COVID19 цар тахал гарснаар одоо байгаа эрүүл мэндийн систем, цалин хөлсний тогтолцоо, ажлын байрны чанар, нийгмийн аюулгүй байдлын сүлжээ, хүний эрхийн асуудал хангалтгүй төвшинд байгаа гэдгийг харуулж өглөө. Тиймээс дэлхий нийтээрээ илүү сайн шударга ногоон эдийн засгийг бий болгох шаардлага тулгарч байна. ДЭЗФ төр хувийн хэвشلүүдийн хамтын ажиллагааг сайжруулах, институцийн тогтолцоог шинэчлэх, эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэхийн тулд судалгаа шинжилгээний үйл ажиллагааг зохион байгуулах, ажлын байрны чанар сургалтуудыг сайжруулах, үйлдвэрүүд нүүрсхүчлийн хийг бууруулахад анхаарах гэх мэт арга хэмжээнүүд авч засгийн газрын хямралын эсрэг одоо авч хэрэгжүүлж байгаа бодлогыг ногоон хөрөнгө оруулалт, бүтэц зохион байгуулалтруу чиглүүлэх хэрэгтэй гэж зөвлөж байна.

5) Олон улсын санхүүгийн байгууллагуудын бодлогын зөвлөмжийн харьцуулалт

Хүснэгт 3. Олон улсын санхүүгийн байгууллагуудаас гаргасан бодлогын зөвлөмжүүд⁶

| ОУВС | ЭЗХАХБ | Дэлхийн банк | ДЭЭФ |
|---|--|--|---|
| Ипотекийн зээл болон хэрэглээний төлбөрийг хойшлуулах | Ипотекийн зээл болон хэрэглээний төлбөрийг хойшлуулах | Ипотекийн зээл болон хэрэглээний төлбөрийг хойшлуулах | Ипотекийн зээл болон хэрэглээний төлбөрийг хойшлуулах |
| Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хугацааг хойшлуулах | Татвар, нийгмийн шимтгэлийн төлбөрийг хойшлуулах | Татвар, нийгмийн шимтгэлийн төлбөрийг хойшлуулах | Татвар, нийгмийн шимтгэлийн төлбөрийг хойшлуулах |
| Хөдөлмөр эрхлэлтийг хангахад дэмжлэг үзүүлэх | Хөдөлмөр эрхлэлтийг хангахад дэмжлэг үзүүлэх | Хөдөлмөр эрхлэлтийг хангахад дэмжлэг үзүүлэх | Хөдөлмөр эрхлэлтийг хангахад дэмжлэг үзүүлэх |
| Зээлийн хугацааг сунгах | Зээлийн хугацааг сунгах | Зээлийн хугацааг сунгах | Зээлийн хугацааг сунгах |
| Олон улсын санхүүгийн байгууллагуудын зээл тусламжийг авах | Олон улсын санхүүгийн байгууллагуудын зээл тусламжийг авах | Олон улсын санхүүгийн байгууллагуудын зээл тусламжийг авах | Олон улсын санхүүгийн байгууллагуудын зээл тусламжийг авах |
| Зээлийн батлан даалт | Зээлийн батлан даалт | Зээлийн батлан даалт | Компаниудад хурдан хугацаанд санхүүжилт олгох үр дүнтэй сувгийг тодорхойлох |
| Бэлэн мөнгөний шилжүүлэг | Бэлэн мөнгөний шилжүүлэг | Бэлэн мөнгөний шилжүүлэг | Бэлэн мөнгөний шилжүүлэг |
| Зайлшгүй шаардлагатай дэд бүтэц хангамж үйлчилгээг тогтмол ажиллуулах | Аялал жуулчлалын салбарт тусд нь бодлого хэрэгжүүлэх | | Дижитал системд гадаад шууд хөрөнгө оруулалт татах |

⁶ Монгол Улсын засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээг “НОГООН” өнгөөр тэмдэглэв.

| | | | |
|---|--|--|--|
| Эмзэг бүлгийн иргэдэд яаралтай тусламж, дэмжлэг үзүүлэх | Эмзэг бүлгийн иргэдэд яаралтай тусламж, дэмжлэг үзүүлэх | Эмзэг бүлгийн иргэдэд яаралтай тусламж, дэмжлэг үзүүлэх | Эмзэг бүлгийн иргэдэд яаралтай тусламж, дэмжлэг үзүүлэх |
| Оюутны зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах | Байгаль орчны асуудалд анхаарах | Үйл ажиллагаа нь зогссон бизнесүүдэд дэмжлэг үзүүлэх | Байгаль орчны асуудалд анхаарах |
| Төв банкнаас зээлийн хөнгөлөлт үзүүлэх | Хямралд өртсөн өрх гэрүүдэд нэг удаагийн төлбөрийг төлж өгөх | Төв банкнаас ААН-үүдэд шууд зээл олгох | |
| ААН-н өмнөх оны татвар болон борлуулалтад үндэслэн дэмжлэг үзүүлэх | Компаний хөрвөх чадварыг түр хугацаанд дэмжих санхүүгийн хэрэгслийг бий болгох | Компаний хөрвөх чадварыг түр хугацаанд дэмжих санхүүгийн хэрэгслийг бий болгох | Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, тогтолцоог шинэчлэх |
| Санхүүгийн салбарын хөрвөх чадварын баталгаа | Ажилгүйдлийн тэтгэмжийн нөхцөлийг уян хатан болгох | Ажилгүйдлийн тэтгэмжийн нөхцөлийг уян хатан болгох | Ажлын байрыг хадгалж үлдэж байгаа компаниудад санхүүгийн дэмжлэг олгох |
| Тэтгэврийн системийг цар тахлын эсрэг бодлого арга хэмжээнүүдэд ашиглахгүй байх | Эрүүл мэндийн үйлчилгээний мэдээллийн болон цахим системийг сайжруулах | Эрүүл мэндийн үйлчилгээний хүчин чадлыг нэмэгдүүлэх | Эрүүл мэндийн үйлчилгээний хүчин чадлыг нэмэгдүүлэх |
| Засгийн газраас ангид цар тахалтай тэмцэх тусгай сан байгуулах | Теле болон дижитал, цахим системийн үйлчилгээг сайжруулах | | |
| Урт хугацаанд ногоон эдийн засагруу шилжих үйл явцыг дэмжих | Урт хугацаанд ногоон эдийн засагруу шилжих үйл явцыг дэмжих | Урт хугацаанд ногоон эдийн засагруу шилжих үйл явцыг дэмжих | Урт хугацаанд ногоон эдийн засагруу шилжих үйл явцыг дэмжих |

Монгол улсын Засгийн газар COVID19 тахлын үеийн эдийн засгийг дэмжих, иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх зорилгоор төсөвт тодотгол хийлгүйгээр 5.1 их наяд төгрөгийн өртөг бүхий багц арга хэмжээг баталсан. Тус багц арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх бодлогот олон улсын санхүүгийн байгууллагуудын зөвлөмж тодорхой хэмжээнд тусгагдсан байна. Тухайлбал:

- ❖ **Эмзэг бүлгийн иргэдэд тусламж үзүүлэх:** 3-р сарын 27-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар төсвийн эмзэг бүлгийн өрх, бизнес эрхлэгчдийг хамгаалах, эдийн засгийг дэмжихэд чиглэсэн цогц арга хэмжээг авч хэлэлцэхээр санал болгов. Үүнд: (i) импортын хэд хэдэн хүнс, эмнэлгийн бүтээгдэхүүний татвараас чөлөөлөх; (ii) хүүхдийн мөнгө, ажилгүйдлийн тэтгэмжийг нэмэгдүүлэх; (iii) 9-р сарыг дуустал ААНОАТ, ХХОАТ, нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх; (iv) ЖДҮ эрхлэгчдэд олгох зээлийн баталгаа, хөгжлийн банкнаас ноолуур үйлдвэрлэгчдэд олгох хөнгөлөлттэй зээлийн хэмжээ нэмэгдсэн. 5-р сарын 6-ны өдөр нийгмийн эмзэг бүлгийг хамгаалах төсвийн хоёр дахь багц арга хэмжээг (ДНБ-ий 2 орчим хувьтай тэнцэх) зарлав. Үүнд: (i) хүүхдийн мөнгөн тэтгэмжийг цаашид нэмэгдүүлэх; (ii) хүнсний талон олгох тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх; (iii) ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй, одой, өнчин, 4-өөс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхийн нийгмийн халамжийн тэтгэврийг нэмэгдүүлэх. Засгийн газар эдгээр арга хэмжээг зардлыг бууруулах замаар бүрэн нөхөх гэж байгаа гэж мэдэгдсэн. 8-р сарын 5-нд засгийн газар COVID-19 санхүүгийн арга хэмжээг сунгах буюу өөрчлөх тухай мэдэгдэв. Жилийн эцэс хүртэл хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд дараах зүйлс орно: (i) хүүхдийн мөнгөн тэтгэмж; (ii) ААНОАТ-аас чөлөөлөх; (iii) түрээсийн орлогын албан татвараас чөлөөлөх; (iv) импортын зарим барааны гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх. Цаашлаад (i) хүнсний талоны тэтгэмжийг нэмэгдүүлэх; (ii) нийгмийн халамж тэтгэвэр нэмэгдүүлэх; (iii) нийгмийн даатгалын шимтгэлийг бууруулах. Эдгээр арга хэмжээг (өмнөх ДНБ-ий нийт дүнгийн 7% орчим хувийг) багтаасан төсвийн тодотголыг 8-р сарын 28-нд УИХ-аас батлав.
- ❖ **Орон сууцны зээл, хэрэглээний төлбөрийг хойшлуулах:** Засгийн газраас энэ оны 1 сарын 15-ны өдрөөс зээлийн эргэн төлөлт нь доголдсон, хүсэлт гаргасан иргэдэд ипотекийн зээлийг 3 хүртэл сараар хойшлуулах, мөн цахилгааны төлбөрийг төлөөгүй тохиолдолд алданги тооцохгүй гэсэн шийдвэр гаргасан.
- ❖ **Татвар нийгмийн даатгалын шимтгэлийг хойшлуулах:** Нийгмийн даатгалын шимтгэлээс 6 сарын хугацаанд хувийн болон төрийн бус байгууллагуудыг чөлөөлөх, 1.5 тэрбум хүртэл төгрөгийн орлоготой ААН-ээс орлогын албан татварыг ыг зургаан сарын хугацаанд авахгүй байх тогтоол шийдвэр гарч хэрэгжиж эхэлсэн байна.
- ❖ **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих:** Түрээсийн хэмжээгээ бууруулсан ААН-үүдийн түрээсийн орлогод ногдох татварыг чөлөөлөх, онцгой байдлын зэрэгт хамаарах хугацаанд бизнес эрхлэгчдийн төлөөгүй

татвар болон НДШ-т тооцох алданги, торгуулийг чөлөөлөх шийдвэрийг гаргасан.

- ❖ **Ажлын байрыг хадгалж үлдсэн ААН-үүдэд дэмжлэг олгох:** Үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа боловч ажлын байраа хадгалсан хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажилтан бүрд гурван сарын хугацаанд сар бүр 200,000 төгрөгийн бэлэн мөнгөний дэмжлэг олгохоор болсон.
- ❖ **Зээлийн батлан даалт олгох:** Барьцаа хөрөнгийн дутагдалтай ААН-ийн 300 хүртэлх сая төгрөгийн зээлд батлан даалт гаргах 103 тэрбум төгрөгийн эх үүсвэр байгаа гэдгийг мэдэгдсэн.
- ❖ **Эрүүл мэндийн үйлчилгээний хүчин чадлыг нэмэгдүүлэх:** Эрүүл мэндийн нэмэлт зардлын 17 тэрбум төгрөгийг (ДНБ-ний 0.04 хувь) баталж, тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх, хяналт, эмнэлгийн хангамж, эмнэлгийн ажилтнуудын илүү цагийн цалин хөлсийг олж авахад хуваарилав. Энэхүү арга хэмжээг Засгийн газрын нөөц сангаас татан төвлөрүүлэх замаар санхүүжүүлдэг.
- ❖ **Төв банкнаас дэмжлэг үзүүлэх:** 3-р сарын 11-ний өдөр Монголбанк (i) бодлогын хүүг 100 bps-ээр 10 хувь болгон бууруулсан; (ii) банкуудын төгрөгийн нөөцийн шаардлагыг 200 нэгжээр бууруулж, 8.5 хувь болгосон; (iii) бодлогын хүүгийн коридорыг ± 1 хувь болгон нарийсгасан. Нөөцийн доод хэмжээ нь банкны системд 324 тэрбум төгрөг (ДНБ-ий 0.8 хувь) байхаар тогтоов. 3-р сарын 18-ны өдөр Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороо нь зохистой шаардлага, зээлийн ангилал, бүтцийн өөрчлөлтийн стандартад санхүүгийн тэвчих арга хэмжээг түр хугацаанд хэрэгжүүлэв. 8-р сарын 7-ны өдөр Монголбанк энэ оны 7-р сарын сүүлээр дуусах байсан санхүүгийн тэвчих арга хэмжээг түр хугацаагаар сунгасан. 4-р сарын 13-ны өдөр Монголбанк: (i) бодлогын хүүг 100 bps-ээс 9 хувь хүртэл бууруулж, (ii) одоо байгаа хэрэглээний зээлийн зээлдэгчдэд үндсэн болон хүүгийн төлбөрөө 12 сар хүртэл хойшлуулах боломж олгов.

Дүгнэлт санал

ДБ, ОУВС, ЭЗХАХБ, ДЭЗФ-н судалгаа шинжилгээний үндсэн дээр улс орнуудад COVID19 тахлын үед үүсч буй эдийн засгийн хямралыг эрсдэл багатай давахад дэмжлэг болох үүднээс гаргасан бодлогын зөвлөмжүүд нь Монгол улсын засгийн газраас баталж хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүдэд тодорхой хэмжээнд тусгагдсан байна. Гэвч тэдгээр бодлогын

арга хэмжээнүүдийн хэрэгжилт хүртээмжтэй байдал эргэлзээтэй байгаа юм. Тухайлбал, бизнесийн байгууллагуудын орлого буурсан энэ үед татварын хөнгөлөлтийн арга хэмжээ авахаас илүү санхүүжилт, хөнгөлөлттэй зээл, санхүүгийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэхэд анхаарах нь илүү үр дүнтэй гэж үзэж байна. Монгол улсын ЗГ-ын хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнд тусгагдаагүй зөвлөмжүүд нь ихэвчлэн санхүүгийн салбарын хөрвөх чадвар, төлбөрийн чадвартай холбоотой арга хэмжээнүүд болох нь хүснэгт 3-с ажиглагдаж байна. Түүнчлэн ногоон эдийн засагруу дэлхий нийтээрээ урт хугацаанд шилжих хэрэгтэй гэдгийг олон улсын байгууллагууд бүгд онцолж байгааг анхаарах хэрэгтэй. Тиймээс Монгол Улсад одоо авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнтэй, хүртээмжтэй байдлыг сайжруулах, тэдгээр арга хэмжээний хэрэгжилтэнд хяналт тавих тал дээр анхаарч, цаашлаад санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад чиглэсэн, мөн ногоон эдийн засагт чиглэсэн арга хэмжээнүүдийг нэмж авах хэрэгтэй гэж дүгнэж байна.

Ашигласан материалын жагсаалт:

- [1] Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. (2019, 4 15). МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД, төрийн албаны ангилалаар. Улаанбаатар, Монгол. Retrieved from Монгол улсын статистикийн мэдээллийн нэгдсэн сан.
- [2] Үндэсний статистикийн хороо. (2017). *НИЙГМИЙН ДААТГАЛ ХАЛАМЖ*. Улаанбаатар: Үндэсний статистикийн хороо.
- [3] Үндэсний статистикийн хороо. (2018). *АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГААНЫ ҮНДСЭН ТАЙЛАН*. Улаанбаатар: Үндэсний статистикийн хороо.
- [4] Adam Tooze. (2020, March 28). *Is the coronavirus crash worse than the 2008 financial crisis*. Retrieved from <https://www.vox.com/2020/3/28/21195207/coronavirus-covid-19-financial-crisis-economy-depression-recession>
- [5] ADB. (April 2020, April). *ASIAN DEVELOPMENT OUTLOOK 2020*. Mandaluyong City: ADB.
- [6] ADB. (September 2020, September). *ASIAN DEVELOPMENT OUTLOOK 2020 Update - Wellness in worrying times*. Mandaluyong City: ADB.
- [7] Alistair Thomson. (2020, March 27). *Joint Statement by the Chair of International Monetary and Financial Committee and the Managing Director of the International Monetary Fund*. Retrieved

- from International Monetary Fund: <https://www.imf.org/en/News/Articles/2020/03/27/pr20114-joint-statement-by-the-chair-of-imfc-and-the-managing-director-of-the-imf>
- [8] Asian Development Bank. (2019, April). *ASIAN DEVELOPMENT OUTLOOK 2019 - Strengthening Disaster Resilience*. Mandaluyong City, Philippines: Asian Development Bank.
- [9] Bank of England. (2020, March). *Covid Corporate Financing Facility (CCFF): information for those seeking to participate in the scheme*. Retrieved from Bank of England: <https://www.bankofengland.co.uk/news/2020/march/the-covid-corporate-financing-facility>
- [10] Chazan, Guy and Richard Milne. (2020, March 02). *Kurzarbeit: a German export most of Europe wants to buy*. Retrieved from Financial Times: <https://www.ft.com/content/927794b2-6b70-11ea-89df-41bea055720b>
- [11] Csaba Feher and Ignatius de Bidegain. (2020, July 20). *IMF*. Retrieved from file:///C:/Users/User/Downloads/enspecial-series-on-covid19pension-schemes-in-the-covid19-crisis-impacts-and-policy-considerations.pdf
- [12] Fazeer Rahim et al. (August 26, 2020). *COVID-19 Funds in Response to the Pandemic*. IMF, Fiscal affairs.
- [13] Ferguson et al. (2020). "Impact of Non-Pharmaceutical Interventions (NPIs) to Reduce COVID19 Mortality and Healthcare Demand.". *Imperial College London*.
- [14] Giovanni Dell'Ariccia et al.,. (2020, April 1). *Economic Policies for the COVID-19 War*. Retrieved from International Monetary Fund: <https://blogs.imf.org/2020/04/01/economic-policies-for-the-covid-19-war/>
- [15] Ikon. (2020, April 17). "Монгол Улсад татвар төлдөг 108.8 мянган ААН бий. Тэдний 99.99 хувь нь зургаан сар НДШ төлөхгүй". Retrieved from Ikon.mn: <https://ikon.mn/n/1uve>
- [16] IMF. (2020, March 23). "IMF's Georgieva: COVID-19 Economic Outlook". Retrieved from International Monetary Fund: <https://www.imf.org/external/mmedia/>
- [17] IMF. (2020, June 3). *IMF*. Retrieved from <https://www.imf.org/en/News/Articles/2020/06/03/pr20232-mongolia-imf-executive-board-approves-us-99m-disbursement-under-the-rfi-address-covid19>
- [18] IMF. (2020, September 30). *International Monetary Fund*. Retrieved from <https://www.imf.org/en/About/Factsheets/Sheets/2020/02/28/how-the-imf-can-help-countries-address-the->

economic-impact-of-coronavirus

- [19] IMF. (2020). *POLICY RESPONSES TO COVID-19*. Retrieved from International Monetary Fund: <https://www.imf.org/en/Topics/imf-and-covid19/Policy-Responses-to-COVID-19>
- [20] International Monetary Fund. (2019, October). *World Economic Outlook*. Washington, DC, USA.
- [21] John Bluedorn, Gita Gopinath, and Damiano Sandri. (2020, April 6). *An Early View of the Economic Impact of the Pandemic in 5 Charts*. Retrieved from International Monetary Fund: <https://blogs.imf.org/2020/04/06/an-early-view-of-the-economic-impact-of-the-pandemic-in-5-charts/>
- [22] John Bluedorn, Gita Gopinath, and Damiano Sandri. (2020, April 6). *International Monetary Fund*. Retrieved from International Monetary Fund: <https://blogs.imf.org/2020/04/06/an-early-view-of-the-economic-impact-of-the-pandemic-in-5-charts/>
- [23] Mariana Mazzucato. (2020, March 18). *"The Covid-19 crisis is a chance to do capitalism differently"*. Retrieved from The Guardian: <https://www.theguardian.com/commentisfree/2020/mar/18/the-covid-19-crisis-is-a-chance-to-do-capitalism-differently>
- [24] Matthew Stephenson. (2020, April 15). *How digital investment can help the COVID-19 recovery*. Retrieved from World Economic Forum: <https://www.weforum.org/agenda/2020/04/covid-19-digital-foreign-direct-investment-economic-recovery/>
- [25] Norman V. Loayza and Steven Pennings. (2020, March 26). *Macroeconomic Policy in the Time of COVID-19: A Primer for Developing Countries*. Retrieved from World Bank: <http://documents.worldbank.org/curated/en/951811585836124198/pdf/Macroeconomic-Policy-in-the-Time-of-COVID-19-A-Primer-for-Developing-Countries.pdf>
- [26] OECD. (2020, March 23). *Education responses to covid-19: Embracing digital learning and online collaboration*. Retrieved from OECD: https://read.oecd-ilibrary.org/view/?ref=120_120544-8ksud7oaj2&title=Education_responses_to_Covid-19_Embracing_digital_learning_and_online_collaboration
- [27] OECD. (2020). *From containment to recovery: Environmental responses to the COVID-19 pandemic*. Retrieved from OECD: https://read.oecd-ilibrary.org/view/?ref=126_126460-1tg1r2aowf&title=From-containment-to-recovery_Environmental-responses-to-the-COVID-19-pandemic

- [28] OECD. (2020). *Government support and Covid 19 pandemic*. Retrieved from OECD: https://read.oecd-ilibrary.org/view/?ref=128_128572-w5qyf5699d&title=Government-support-and-the-COVID-19-pandemic
- [29] OECD. (2020, March 20). *Supporting people and companies to deal with the COVID-19 virus: Options for an immediate employment and social-policy response*. Retrieved from OECD: https://read.oecd-ilibrary.org/view/?ref=119_119686-962r78x4do&title=Supporting_people_and_companies_to_deal_with_the_Covid-19_virus
- [30] OECD. (2020, April 03). *The territorial impact of COVID-19: managing the crisis across levels of government*. Retrieved from OECD: https://read.oecd-ilibrary.org/view/?ref=128_128287-5agkkojaaa&title=The-territorial-impact-of-covid-19-managing-the-crisis-across-levels-of-government
- [31] OECD. (2020, April 15). *Tourism Policy Responses*. Retrieved from OECD: https://read.oecd-ilibrary.org/view/?ref=124_124984-7uf8nm95se&title=Covid-19_Tourism_Policy_Responses
- [32] OECD. (2020, October 19). What is the impact of the COVID-19 pandemic on immigrants and their children?
- [33] Teresa Curristine, Laura Doherty, Bruno Imbert, Fazeer Sheik Rahim, Vincent Tang, and Claude Wendling. (2020, June 29). Budgeting in a Crisis: Guidance for preparing the 2021 budget.
- [34] World Bank. (2019, June 21). *Mongolia's 2018 Poverty Rate Estimated at 28.4 Percent*. Retrieved from World Bank: <https://www.worldbank.org/en/news/press-release/2019/06/21/mongolias-2018-poverty-rate-estimated-at-284-percent>
- [35] World Bank. (2020, February 11). *How the World Bank Group is helping countries with COVID-19 (coronavirus)*. Retrieved from World Bank: [worldbank.org/en/news/factsheet/2020/02/11/how-the-world-bank-group-is-helping-countries-with-covid-19-coronavirus](https://www.worldbank.org/en/news/factsheet/2020/02/11/how-the-world-bank-group-is-helping-countries-with-covid-19-coronavirus)
- [36] World Bank. (2020, June). World Bank Group Covid 19 response approach paper - Saving Lives, Scaling up impact and Getting back on track.
- [37] World Bank. (2020, April 02). *World Bank Group Launches First Operations for COVID-19 (Coronavirus) Emergency Health Support, Strengthening Developing Country Responses*. Retrieved from World Bank: <https://www.worldbank.org/en/news/press-release/2020/04/02/world-bank-group-launches-first-operations-for-covid-19-coronavirus-emergency-health-support-strengthening->

developing-country-responses

- [38] World Bank Mongolia. (2020, April 02). *World Bank Mongolia*. Retrieved from World Bank: <https://www.worldbank.org/mn/news/press-release/2020/04/02/the-world-bank-approves-269-million-for-mongolias-covid-19-coronavirus-emergency-response>
- [39] World Economic Forum. (2020, April). *Emerging Priorities and Principles for Managing the Global Economic Impact of COVID-19*.